



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/Б/С

Улаанбаатар хот

Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын ажилтан, албан хаагчдын тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2017 оны 289 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын ажилтан, албан хаагчдын тэмцээнийг 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороонд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.000.000 /нэг сая/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.


4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа /- т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны... сарын...-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт



Нийслэл, дүүргийн биеийн тамир,
спортын хороодын ажилтан, албан хаагчдын
тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 1 x 160.000 төг = 160.000 төг 1 x 140.000 төг = 140.000 төг 1 x 100.000 төг = 100.000 төг	400.000
2.	Багийн шагнал	300.000
3.	Тээврийн зардал	300.000
Нийт дүн		1.000.000